

**Монгол Улс дахь худалдааны эрх
зүйн зохицуулалтын асуудал**

Issues Regarding Legal Regulation of Trade in Mongolia

Энхээгийн Туулайхүү

Хууль зүйн ухааны магистр (LL.M.)

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,

Улаанбаатар хот, Монгол Улс.

e.tuulaikhuu@num.edu.mn



[Товч утга]

Монгол Улсад худалдааг хуулиар хэрхэн зохицуулах асуудал судалгааны нээлттэй сэдэв хэвээр буйг харгалзан энэ өгүүлэлд Монгол Улсын худалдааны эрх зүйн орчин, Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын үүрэг амлалт болон худалдааны гол түнш орнуудын туршлагыг судалж, Монгол Улсад худалдааг төрөөс зохицуулах, тэр дундаа хуулиар зохицуулах асуудлыг тодорхойлж, санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорив. Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын худалдааны гол түншүүд гадаад худалдааг тусдаа хуулиар зохицуулдаг бөгөөд үүнийг Монгол Улсад ч мөн адил хэрэгжүүлэх боломжтой. ДХБ-ын гишүүн орны хувьд Монгол Улс худалдааны бодлогоо ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд боловсруулж, зохицуулалтаа тодорхойлох нь олон улсын худалдааны дүрмээр дэлхийн улсуудтай худалдаа хийж үр ашиг хүртэх, түүнээс үүсэх эрсдэл, эрх зүйн асуудлыг мөн тийнхүү зохицуулахад чухал. Худалдааны хууль нь гадаад, дотоод худалдааг нэгэн дор буюу хамтад нь гэхээсээ гадаад худалдааны төрийн бодлогын үндсийг тодорхойлдог нь олон улсын нийтлэг жишиг байна. Үүнийг даган гадаад худалдааг тусдаа хуулиар зохицуулах бол дотоод худалдааны зохицуулалтыг салбар бүрээр тусгайлан тодорхойлох, дотоод худалдааг салбар бүрээр нарийвчлан зохицуулах нь зүйтэйг энэ өгүүлэлд онцлов. Тухайлбал, жижиглэн худалдааны салбарт гадаадын сүлжээ дэлгүүрүүдийн нөлөөг анхаарч, дотоодын жижиглэн худалдаачдыг хамгаалах бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

[Түлхүүр үг]

Худалдаа, худалдааны хууль, худалдааны бодлого, гадаад худалдаа, дотоод худалдаа, Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрүүд.

I. Оршил

Монгол улс 1997 онд ДХБ-д элссэн бөгөөд тэр цагаас даруй 28 жил болж байна. Энэ хугацаанд Монгол Улс ДХБ-ын гишүүн болсон нь зүйтэй эсэх, зөв цагтаа гишүүнээр элссэн эсэх, Монгол улсад худалдааг хууль зүйн хувьд хэрхэн зохицуулах буюу бие даасан худалдааны хуультай байх эсэх тухай яриа байсаар буй. Энэ өгүүлэл нь төрийн бодлогын хүрээнд худалдааг тусдаа хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлага бий эсэх, бий бол түүний зохицуулалтын хамрах хүрээ, зохицуулах асуудлыг тодорхойлоход дэм болох, энэ талаар хувилбар дэвшүүлэх зорилготой. Худалдааны харилцааг тусгайлсан хуулиар нэгтгэн зохицуулснаар эдийн засгийн хувьд ямар үр дагавар үүсэх, энэ нь манай улсад хэр ашигтай байх вэ гэдэгт төрийн зүгээс нухацтай дүгнэлт хийгээгүй. Монгол Улсад худалдааг төрөөс зохицуулах, тэр дундаа хуулиар зохицуулах, ингэхдээ ямар хүрээнд, хэрхэн зохицуулах асуудал яригдсаар ирсэн боловч төрөөс албан ёсны баримт бичиг хараахан гараагүй тул судалгааны нээлттэй сэдэв хэвээр байна. Тиймээс энэ өгүүлэлд Монгол Улсын худалдааны эрх зүйн өнөөгийн орчин буюу худалдааг зохицуулж буй асуудлыг эхлээд тодруулж, дараагаар нь ДХБ-ын эрх зүйн зохицуулалт болон худалдааны гол түнш зарим улсын туршлагыг судалж, эцэст нь судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, санал, зөвлөмж дэвшүүлэв. Аливаа олон улсын гэрээ нь улсуудын нийтлэг тохиролцоог илтгэдэг бөгөөд дотоодод шууд хэрэглэхүйц зохицуулалтаас гадна дотооддоо бодлого, үндэсний эрх ашигт нийцүүлэн нарийвчлан зохицуулах орон зай (regulatory space)-г мөн олгодгийн хувьд экспор, импортын талаарх ДХБ-ын зохицуулалтыг 1 дүгээр бүлэгт шинжилсэн. 2 дугаар бүлэгт БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, Энэтхэг улсуудын худалдааны зохицуулалтыг судалсан. БНХАУ, ОХУ нь Монгол улсын газарзүйн хөрш бол Япон, БНСУ, Энэтхэг нь голлох гуравдагч хөршүүд юм. Монгол Улс түүхэн талаас БНХАУ, ОХУ-тай их хэмжээнд худалдаа хийж ирсэн бол 1990-ээд онд зах зээлийн эдийн засагт шилжсэнээр Япон, БНСУ зэрэг гуравдагч хөршүүдтэй худалдааны харилцаа амжилттай хөгжиж байна. Япон нь Монгол Улсын хувьд хамгийн анх Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан гадаад улс бол БНСУ-тай мөн ийм төрлийн хэлэлцээр байгуулахаар талууд хэлэлцээ хийж буй билээ. Энэтхэг улс нь Монгол улстай улс төр, эдийн засгийн харилцааг идэвхтэй өрнүүлж байгаа бөгөөд ирээдүйд Монгол улсын худалдааны нэг гол түнш болох төлөвтэй. 3 дугаар бүлэгт Монгол улс дахь худалдааны хууль (trade law)-ийн хэрэгцээ, шаардлагыг эргэцүүлж, хэрэв ийм хууль байх тохиолдолд хамрах хүрээг хэрхэн тодорхойлох талаар авч үзэв.

II. Монгол Улсын худалдааны эрх зүйн орчин ба ДХБ-ын импорт, экспортын эрх зүйн зохицуулалт, Монгол Улсын үүрэг, амлалт

1. Монгол Улсын худалдааны эрх зүйн орчин (худалдааг зохицуулж буй байдал)

Худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлсэн эсэх тухай асуудлыг тооны бус агуулгын үүднээс авч үзвэл худалдааны салбарт нэгдсэн бодлого, түүнийг дагасан зохицуулалт байхгүй. Тэр дундаа худалдааны асуудлыг төрийн эрх барих өөр өөр байгууллага, албан тушаалтан хариуцаж байна. Жишээлбэл, Улсын Их Хурал худалдааны тарифын асуудлыг, Шадар сайд чөлөөт бүсийн асуудлыг, Гадаад харилцааны яам Дэлхийн худалдааны байгууллагатай харилцах асуудлыг, Сангийн яам гаалийн бодлогын асуудлыг, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам дотоод худалдааны асуудлыг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам газрын баялгийн экспортын асуудлыг хариуцаж байна. 2025 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 931 хууль¹ дотор худалдааны асуудлыг нэгдсэн/цогц байдлаар зохицуулсан хууль байхгүй, харин олон тооны хууль дотор хамаарал бүхий заалтуудыг янз бүрээр оруулах байдлаар хэсэгчилсэн маягтай зохицуулсаар ирсэн. 2021 онд хийсэн нэгэн судалгаагаар 57 хуульд худалдаатай холбоотой 100 гаруй заалт байгаа тухай мэдээ байна.²

Монгол Улс 1997 онд ДХБ-д элссэн. Ингэснээр Монгол Улс ДХБ-ыг үүсгэн байгуулах тухай Марракешийн хэлэлцээр, түүний хавсралтад заасан олон талт гэрээний оролцогч болсон. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”; мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасны дагуу ДХБ-ын хэлэлцээрүүд нь Монгол Улсад хүчин төгөлдөр эрх зүйн эх сурвалж болно.

ДХБ-ын “Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр”-ийг дотоодод хэрхэн хэрэгжүүлэх журмыг боловсруулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан ба эндээс өөрөөр ДХБ-ын зохицуулалтыг нарийвчилсан баримт бичиг хараахан гараагүй байна. Гадаад худалдааны харилцааг тусгайлсан хуулиар нэгтгэн зохицуулснаар эдийн засгийн хувьд ямар үр дагавар үүсэх, энэ нь манай улсад хэр ашигтай байх вэ гэдэгт төрийн

¹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn>

² Худалдааны тухай хуулийн төслийг боловсруулна <https://ubn.mn/p/16588>

зүгээс нухацтай дүгнэлт хийгээгүй. ДХБ-д гишүүнээр элссэнээс хойших хугацаанд гадаад худалдааны харилцааг зохицуулсан тусдаа хуульгүй байсан болон дотоодын зах зээлээ хамгаалах асуудлыг эдийн засгийн салбарын холбогдох хуулиудаар хэсэгчлэн зохицуулж ирсний үр дагаврыг мөн нарийвчлан үнэлээгүй байна.³

Монгол Улсад дотоод худалдааны чиглэлд төрийн зохицуулалтыг нэгтгэсэн хууль мөн үйлчилдэггүй. Үүний оронд энэ чиглэлд өөр өөр хууль үйлчилдэг буюу тухайлбал Иргэний хууль (2002)-аар эрх зүйн этгээд (иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага)-ийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг; Компанийн тухай хууль (2011)-аар компани үүсгэн байгуулах, бүртгүүлэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг тогтоох, компани татан буулгахтай холбогдсон харилцааг; Нөхөрлөлийн тухай хууль (1995)-аар нөхөрлөлийг үүсгэн байгуулах, бүртгүүлэх, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтцийг тогтоох, бүртгэл, тайлан гаргах, өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдон үүсэх харилцааг; Хөрөнгө оруулалтын тухай хууль (2013)-аар Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын эрх зүйн нийтлэг баталгааг тогтоох, хөрөнгө оруулалтыг дэмжих, тогтворжуулах татварын орчныг тогтоох, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээ, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг; Өрсөлдөөний тухай хууль (2010)-аар аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг; Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль (2003)-аар бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг тус тус зохицуулж байна.

Иргэний хууль нь арилжааны зохицуулалтыг агуулдаг боловч “аж ахуй үйл ажиллагааны талаарх нэгдсэн зохицуулалт байхгүй, дийлэнх зохицуулалт нь иргэн, аж ахуй эрхлэгчийн харилцааны ялгамжтай шинжийг агуулгаагүй буюу нийтлэг зохицуулалттай” гэж зарим судлаач дүгнэжээ.⁴ Тэдний үзэж буйгаар “итгэмжлэлээр төлөөлөх

³ М.Уянга, *Олон улсын худалдааны эрх зүй ба Дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээ*, УБ: Соёмбо принтинг, 2016, 211 дэх тал

⁴ Ханнс Зайделийн сан, *Эрх зүйн боловсрол академи, Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааны тайлан* (УБ.,2019), 88

болон аж ахуйн үйл ажиллагаанд төлөөлөх зохицуулалт байхгүй ба аж ахуй эрхлэгчийн бүртгэлийг зөвхөн хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэгчээр [Монгол Улсад] хязгаарладаг” аж.⁵ Энэ үндсэн дээр Арилжааны хуулийн төслийг эцэслэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/304 тоот тушаалаар байгуулжээ.⁶ Хуулийн төслийг УИХ-д хараахан өргөн мэдүүлээгүй байгаа тул төслийн агуулга, боловсруулалт ямар шатанд яваа талаар албан ёсны мэдээлэл одоогоор гараагүй байна. Гэхдээ Арилжааны кодексын нийтлэг жишгээр тус хуулиар аж ахуй эрхлэгч хоорондын харилцаа буюу тэдгээрийн хоорондын үйл ажиллагааг гол төлөв зохицуулах нь тодорхой.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын зах зээлд гадаадын сүлжээ дэлгүүрүүд (CU, GS25 зэрэг) жижиглэн худалдааны салбарт эрчимтэй нэвтэрч байна. Эдгээр нь олон улсын зах зээлд танигдсан байдал, туршлага, менежмент, үр ашигт байдал, эзэмшдэг техник, технологийн үүднээс дотоодын салангид жижиглэн худалдаачид (хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ, мини маркет)-тай шууд харьцуулагдахгүй⁷ буюу хөгжлийн харьцангуй өөр түвшинд байдаг. Гадаадын сүлжээ дэлгүүр орж ирснээр тэдний нэрийн брэнд бараа нь импортын бүтээгдэхүүн байхаас гадна өөрсдийн сүлжээгээр худалдаалах бүтээгдэхүүн нийлүүлэгчид өндөр шалгуур тогтоодог нь орон нутгийн жижиг үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчид бүтээгдэхүүнээ зах зээлд хүргэх хуваарилалтын сувгаа алдахад хүргэх эрсдэлтэй.⁸

Судлаач Г.Мөнхбаясгалан, Р.Шарбанди, Ж.Тунгалаг нарын үзэж буйгаар “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн ирээдүйн төлөв байдлыг илэрхийлсэн, урт, богино хугацаанд төрөөс баримтлах бодлого, зорилт, холбогдох баримт бичгүүдэд жижиглэн худалдааны салбарт хамааралтай тусгайлсан бодлого, зорилт тусгагдаагүй”⁹ буюу үндсэндээ зохицуулалтгүй байна.

2. Дэлхийн худалдааны байгууллагын олон талт хэлэлцээр ба Монгол улсын хүлээсэн үүрэг амлалт, дотоодын зохицуулалтад тавигдах хязгаарлалт, орон зай-боломж

2.1. ДХБ-ын импортын болон экспортын татварын бодлого, зохицуулалт ба Монгол Улсын үүрэг амлалт

дахь тал

⁵ Мөн тэнд.

⁶ Арилжааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг хуралдлаа <https://www.unuudur.mn/a/259748>

⁷ Г.Мөнхбаясгалан, Р.Шарбанди, Ж.Тунгалаг, *Глобал жижиглэн худалдааны орчин дахь Монгол Улс* (Journal of Business and Innovation (2023/№5(3), 154–167) <https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/article/view/2374>

⁸ Мөн тэнд, 158 дахь тал

⁹ Мөн тэнд, 161 дэх тал

А. *Импортын татвар*. Импортын тоон хязгаарлалтаас ялгаатай нь¹⁰ ДХБ-ын гэрээ хэлэлцээрээр, ялангуяа ТХЕХ-ээр импортод гаалийн татвар (тариф) ногдуулахыг хориглоогүй бөгөөд ДХБ-ын гишүүний дотоодын зах зээлээ хамгаалах “худалдааны бодлогын хууль ёсны арга хэрэгсэл” гэж үздэг. Ингэхдээ ДХБ-ын гишүүд гаалийн татварыг харилцан ашигтай байдлаар буулгах талаарх хэлэлцээ хийх шаардлагатай байдаг. Тарифын буултын талаарх хэлэлцээний үр дүнд гаалийн татварын боломжит дээд түвшинг тогтоох ба улмаар тухайн тогтоосон түвшингээс хэтрүүлэн өсгөхгүй байх амлалт өгдөг. Импортын барааны хувьд улс бүр ДХБ-д элсэхдээ тарифын буултын жагсаалт (tariff concessions or tariff bindings) гаргах үүрэг хүлээдгийн хувьд түүнд заасан хэмжээгээр илүүгүй тариф (гаалийн татвар) ногдуулах эрхтэй. Монгол Улсын хувьд ДХБ-д нэгдэн орохдоо тарифын түвшинг ихэнх бараанд үнийн дүнгийн 20 хувиас хэтрүүлэхгүй байх үүрэг хүлээсэн.¹¹

Б. *Экспортын татвар*. Экспортын татвар гэдэгт бараа бүтээгдэхүүний экспортод ногдуулж буй гаалийн болон бусад татвар, хураамжийг ойлгоно. Экспортын татварыг төлсний үндсэн дээр тухайн бараа бүтээгдэхүүн улсын хилээр гарах боломжтой болдог тул татварын хэмжээ тухайн барааны экспортын хэмжээнд нөлөөлнө. ДХБ экспортын татварын хувьд гишүүддээ бодлогоо өөрөө тодорхойлохыг өргөн боломж олгосон. Гэхдээ Тарифын буултын жагсаалтдаа цаашид хэрэглэх импортын татвараас гадна экспортын татварын хэмжээгээ мөн тохирсон ДХБ-ын гишүүд (Австрали зэрэг) байдаг. Монгол Улсын хувьд ийм үүрэг хүлээгээгүй буюу тарифын буултын жагсаалтад экспортын татварын хэмжээг тохироогүй.

Импорт, экспортын татвар хэрэглэхэд хамаарах ТХЕХ дэх нийтлэг дүрэм.

Үндэсний нэн таатай дэглэм (Most-favored nation treatment). ТХЕХ-ийн 1 дүгээр зүйлд зааснаар ДХБ-ын гишүүд өөр хоорондоо хийх худалдаандаа үндэсний нэн таатай дэглэмийг баримтлах үүрэгтэй. Үүнийг импорт, экспортын татварын жишээн дээр тайлбарлавал ДХБ-ын нэг гишүүн ямар нэгэн бараанд импорт, экспортын татвар ногдуулах шийдвэр гаргавал энэ нь ижил барааны хувьд ДХБ-ын бусад бүх гишүүдэд адил хэмжээтэй байх шаардлагатай гэсэн үг. Мөн ТХЕХ -ийн II:1 (а) хэсэгт “гишүүн бүр нөгөө гишүүнтэй хийж

¹⁰ Тодорхой тохиолдолд зөвшөөрснөөс бусад тохиолдолд барааны худалдаа (экспорт, импортын аль алинд)-д тоон хязгаарлалтыг оногдуулахыг хориглодог буюу өөрөөр хэлбэл квотын үндсэн дээр барааны импорт, экспортод хязгаарлалт тогтоохыг зөвшөөрдөггүй.

¹¹ Монгол Улс ДХБ-д нэгдэн орохдоо гаргасан барааны талаарх буулт, үүрэг амлалтуудын жагсаалт (“ДХБ дахь Монгол улс: Албан ёсны баримт бичгүүдийн эмхтгэл”, 2 дахь хэвлэл, УБ.,2003, 65 дах тал)

буй худалдаа (commerce)-нд тарифын буултын жагсаалтад зааснаас багагүй таатай нөхцөлийг олгоно” хэмээн заасан. Энд хэрэглэсэн “commerce” гэдэгт импорт, экспортын аль алиныг багтаан ойлгоно гэж үздэг.¹²

ДХБ-д нэгдэн орох тухай протокол ба экспортын татвар ногдуулах эрх. ТХЕХ-ээр экспортын татварыг нарийвчлан зохицуулаагүй (шууд хориглоогүй) боловч зарим улс ДХБ-д нэгдэн орох тухай протоколдоо экспортын татвар хэрэглэх эсэх, хэрэглэх бол ямар хэмжээнд, ямар хязгаарлалттайгаар хэрэглэх тухай илүү нарийвчилсан үүрэг хүлээсэн байна. Одоогоор БНХАУ, Болгар, Монгол, Латви, Эстони, Гүрж, Хорват, Саудын Араб, Вьетнам, Украин, Монтенегро, ОХУ, Лаос, Тажикистан, Казакстан, Афганистан зэрэг 15 улс ДХБ-д нэгдэн орохдоо ДХБ-ын гэрээ хэлэлцээрт зааснаас илүү хатуу үүрэг хүлээсэн. Энэ нь угтаа ДХБ-ын барааны худалдааны эрх зүйн гол баримт бичиг болох ТХЕХ-т байхгүй нэмэлт нөхцөл болсон.¹³ Тухайлбал Монгол улсын ДХБ-д нэгдэн орох тухай протоколын 1 дүгээр хэсгийн 3 дахь хэсэгт ДХБ-д нэгдэн орох тухай ажлын хэсгийн илтгэлд дурдсан тодорхой хугацаа бүхий үүрэг амлалтуудын хэрэгжилтийг Монгол улс хангахаар заажээ.¹⁴ Ажлын хэсгийн илтгэлд дурдсанаар экспортын хязгаарлалттай холбоотой дараах үүрэг хүлээсэн байна. Үүнд:

24. Боловсруулаагүй ноолуурын экспортын хоригийг Засгийн газар 1996 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хадгалж, цаашид үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй хэмжээний экспортын татвар тогтооно гэж Монголын төлөөлөгч мэдэгдсэн. Экспортын тэрхүү татварыг Монгол улс ДХБ-д нэгдэн орсноос 10 жилийн туршид зохих шатлалыг дамжин хална. Монголын төлөөлөгч тэрчлэн хар болон өнгөт металын тухайд экспортын лицензийн шаардлагыг 1997 оны 1 дүгээр сарын 1 гэхэд хална гэж мэдэгдсэн...¹⁵

Ийнхүү ДХБ-д нэгдэн орохдоо тухайн үед хэрэглэж байсан түүхий

¹² Peter Van den Bossche and Werner Zdouc, *The Law and Policy of the World Trade Organization: Text, Cases and Materials* (Cambridge: Cambridge University Press, 2017), p.471

¹³ ДХБ-ын гэрээ хэлэлцээрийн харилцан хамаарал ба ДХБ-д нэгдэн орох тухай протоколын харилцан хамаарлын талаар ДХБ-ын маргаан шийдвэрлэх практикт экспортоос үүдэлтэй хэд хэдэн маргаан гарч байсан бөгөөд ДХБ-д нэгдэн орох тухай протоколд хязгаарлалт тогтоосноос бусад тохиолдолд экспортын татвар чөлөөтэй тогтоож болно гэж дүгнэсэн байдаг. Энэ талаар дэлгэрэнгүйг Э.Туулайхүү, Экспортын хязгаарлалтад хамаарах ДХБ-ын эрх зүйн зохицуулалт ба Монгол Улсын нөхцөл байдал (Эрх зүй сэтгүүл 2020/№1, 113-133) өгүүллээ үзнэ үү.

¹⁴ ДХБ дахь Монгол улс: Албан ёсны баримт бичгүүдийн эмхтгэл, 2 дахь хэвлэл, УБ.,2003, т.61

¹⁵ Мөн тэнд, т.40

(боловсруулаагүй) ноолуурын экспортын хязгаарлалтыг нэгдэн орсноос хойш аажмаар буюу 10 жилийн дотор халах үүрэг хүлээсэн. 1996 оны 3 дугаар сарын 29-ний өдөр “Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хууль” баталсан бөгөөд тус хуулийн 2 дугаар зүйлд зааснаар ямааны боловсруулаагүй ноолуурт килограмм тутамд 4000 төгрөгийн экспортын гаалийн татвар ногдуулж байжээ. Уг татварыг 2009 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон. Энэ тухай 2014 оны Монгол улсын Худалдааны бодлогыг хянан үзэх талаарх ДХБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын тайлан (Mongolia’s Trade Policy Review Report by WTO Secretariat)-д “Монгол улс боловсруулаагүй ноолуурт хэрэглэж байсан экспортын татвараа 2009 онд халсан” хэмээн мөн дурдсан байна.¹⁶

Үүнээс гадна тус хуулиар хаягдал хар болон өнгөт төмөрлөг, тэмээний боловсруулаагүй ноос зэрэгт экспортын татвар ногдуулж байсныг 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн болон 2016 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиудаар тус тус хүчингүй болгожээ.

Хөгжиж буй улсад олгох хөнгөлөлттэй дэглэм. Өмнө өгүүлснээр ДХБ-д нэгдэн орох тухай протоколд тусгайлан үүрэг амлалт авснаас бусад тохиолдолд экспортын татвар хэрэглэх эсэх нь ДХБ-ын гишүүн улсын бүрэн эрх байна.

ДХБ-ын гэрээ хэлэлцээрүүдэд хөгжиж буй орнуудад онцгой эрх олгох, хөгжингүй орнуудаас хөгжиж буй оронд ДХБ-ын бусад гишүүнд олгож байгаагаас илүү таатай боломж олгох талаар зохицуулалт бий. Ийм зохицуулалтыг нийтэд нь “хөгжиж буй оронд олгох онцгой, ялгаатай дэглэм”(Special and Differential Treatment) гэж нэрлэдэг ба дараах онцлогтой. Үүнд:

а) ДХБ-ын гэрээ хэлэлцээрүүд болон тэдгээрээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд арай урт хугацаа олгох;

б) Хөгжиж буй орны худалдаа хийх боломжийг дээшлүүлэх арга хэмжээ авах;

в) Хөгжиж буй орны худалдааны ашиг сонирхлыг хамгаалахыг ДХБ-ын бүх гишүүнд үүрэг болгох;

д) ДХБ-ын үйл ажиллагаанд оролцох, маргаан шийдвэрлэх, техникийн стандартыг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орны чадавхыг сайжруулахад туслалцаа үзүүлэх;

е) Буурай хөгжилтэй оронд хамаарах зохицуулалт.¹⁷

Enabling clause. Хөнгөлөлтийн ерөнхий систем (Generalized

¹⁶ Mongolia’s Trade Policy Review Report by the WTO Secretariat (12 December 2014) https://www.wto.org/english/tratop_e/tpr_e/tp397_e.htm.

¹⁷ https://www.wto.org/english/tratop_e/dda_e/status_e/sdt_e.htm

System of Preferences, GSP) дагуу хөгжингүй орны зүгээс ялгаатай, илүү таатай нөхцөлийг хөгжиж буй оронд олгож болох ба үүнийг бусад гишүүнд жигд олгох үүрэг хүлээхгүй. Үүгээрээ ТХЕХ-ийн хэлэлцэн тохирогч нэг тал нь аливаа улсад олгосон таатай дэглэмийг бусад гишүүн улсад нэгэн адил олгох ёстой гэсэн үндэсний нэн таатай дэглэмийн үзэл санааг хөнддөг. ДХБ-ын маргаан шийдвэрлэх байгууллага *EC-Tariff Preferences*¹⁸ хэргийг шийдвэрлэхдээ Enabling clause-г ТХЕХ-ийн нэг бүрэлдэхүүн хэсэг, олон улсын худалдаанд үл ялгаварлах нэг гол зарчим болох үндэсний нэн таатай дэглэм (ТХЕХ-ийн 1 дүгээр зүйл) үйлчлэхгүй байх нэг тохиолдол мөн хэмээн хүлээн зөвшөөрсөн. ТХЕХ-ийн нийтлэг дүрмээр хэлэлцээрийн талууд бие биендээ таатай нөхцөлийг харилцан бие биедээ олгох ёстой бол Enabling clause-ийн дагуу хөгжиж буй оронд хөгжингүй орон хөнгөлөлттэй нөхцөл олгосны хариуд тухайн хөгжиж буй орон заавал ижил нөхцөл олгох албагүй. Хөгжиж буй оронд хөнгөлөлттэй дэглэмийн гол суурь нь хөнгөлөлтийн ерөнхий систем бөгөөд дараах үндсэн шинжтэй. Үүнд:

а) Хөгжиж буй орноос гарал үүсэлтэй бүтээгдэхүүнд бусад улсаас гаралтай бараанд олгож байгаагаас хөнгөлөлттэй дэглэм олгох (MFN-тэй нийцэхгүй байж болох талаар дээр дурдсан);

б) Тарифын болон тарифын бус аль ч хэлбэрээр хөнгөлөлтийн нөхцөлийг тохиролцож болох;

в) Хөгжиж буй орнуудын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж буй тохиолдолд ТХЕХ-ийн 24 дүгээр зүйлд заасан шаардлагуудыг багасгах;

д) Хөгжиж буй болон буурай хөгжилтэй орныг хооронд нь ялган буурай хөгжилтэй оронд нэмэлт хөнгөлөлт үзүүлэх;

е) Хөгжиж буй оронд олгох хөнгөлөлттэй дэглэмийн хүрээнд авах арга хэмжээ нь хөгжиж буй орны хөгжил, санхүүгийн болон худалдааны хэрэгцээнд нийцсэн байх;

ф) Enabling clause-ийн хүрээнд авах арга хэмжээг хүлээн авагч ДХБ-ын гишүүн ДХБ-д мэдэгдэж, энэ талаар зөвлөлдөх;

г) Донор орнууд хөнгөлөлт үзүүлснийхээ хариуд ашиг шаардахгүй байх;

х) Буурай хөгжилтэй орон өөрийн хөгжил, санхүүгийн болон худалдааны хэрэгцээ шаардлагыг эрсдэлд оруулах үүрэг амлалт авахгүй байх;

Энэ нь хөгжиж буй орнуудыг эдийн засгийн нөхцөл байдлаа

¹⁸ European Communities - Conditions for The Granting of Tariff Preferences to Developing Countries (2004)

сайжруулах хүртэл олон талт худалдааны системд тэдгээрийг илүү бүрэн дүүрэн оролцуулахад дэмжих зорилготой.¹⁹

2.2. Экспортыг дэмжих татаасын зохицуулалт ба Монгол Улсын үүрэг амлалт

Улс орнууд өөрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чухал зорилгын төлөө татаас олгохыг ямар нэгэн хэмжээгээр дэмждэг буюу хэрэглэдэг.²⁰ ТХЕХ-ийн болон ДХБ-ын практикт татааст, ялангуяа эдийн засгийн ач холбогдол бүхий стратегийн салбар, хөдөө аж ахуйн салбар дахь татааст холбогдох маргаан олон гарсаар ирсэн.

Татаасын тодорхойлолт. ДХБ-ын хүрээнд татаасыг ТХЕХ-ийн 6, 16 дугаар зүйл, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр (Agreement on Subsidies and Countervailing Measures)-ээр зохицуулдаг. Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт засгийн газар болон төрийн байгууллагаас, тухайлбал зээл зэрэг эх үүсвэрийг шууд шилжүүлэх байдлаар ашиг өгч буй санхүүгийн хувь нэмэр (financial contribution)-ыг татаас (subsidy) хэмээн тодорхойлдог. Мөн татаас гэдэгт төрөөс хураах ёстой орлогоосоо татгалзах, хурааж авахгүй байх (татварын хөнгөлөлт г.м); нийтлэг дэд бүтцээс бусад бараа, үйлчилгээгээр хангах, бараа худалдан авах зэрэг хамаарна.²¹ Татаас гэж үзэхийн тулд (i) санхүүгийн хувь нэмэр; (ii) засгийн газар эсхүл төрийн байгууллагаас олгосон байх; (iii) ашиг бий болгох гэсэн гурван гол нөхцөлийг хангасан байх шаардлагатай. Санхүүгийн хувь нэмэр гэдэгт буцалтгүй тусламж (тэтгэлэг), зээл, зээлийн баталгаа, хувьцаанд хөрөнгө оруулах, бараа худалдан авах зэрэг хамаарна. Санхүүгийн хувь нэмрийг тухайн гишүүн улсын нутаг дэвсгэрийн хүрээнд төрийн байгууллагаас шууд эсхүл төрийн байгууллагын заавраар олгосон байна. Ийнхүү төрөөс өгч буй санхүүгийн хувь нэмэр нь “ашиг” бий болгож байх шаардлагатай бөгөөд үгүй бол татааст тооцогдох боломжгүй. Татаас бүхий барааны импорт дотоодын үйлдвэрлэлд нь сөргөөр нөлөөлсөн гэж бусад улс үзвэл тухайн татаасыг саармагжуулах арга хэмжээ (countervailing measures) авч болно. Тиймээс ДХБ-ын эрх зүйд “татаас, саармагжуулах арга хэмжээ”-г хамтад нь зохицуулдаг. Ингэхдээ татаас нь тодорхой үйлдвэрлэл, аж ахуйн нэгж эсхүл тодорхой бүлэг үйлдвэрлэл, аж ахуй нэгж рүү тусгайлан чиглэсэн байж Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн үйлчлэлд хамаарна.²²

¹⁹ Mitsuo Matsushita, Thomas J. Schoenbaum, Petros C. Mavroidis, Michael Hahn. *The World Trade Organization: Law, Practice, and Policy* (Oxford: Oxford University Press, 2015), pp.701-702

²⁰ Г.Сэээр, *Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал*, УБ., 2000, 72 дахь тал

²¹ Татаас болон саармагжуулах арга хэмжээний хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийг үз.

²² https://www.wto.org/english/tratop_e/scm_e/subs_e.htm

Хориглосон татаас. Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрээр хоёр төрлийн татаасыг зохицуулсан. Эхнийх нь хориглосон татаас буюу экспортын гүйцэтгэлийг хангах болзол бүхий экспортын татаас (export subsidy)²³ болон импортын барааны оронд дотоодын барааг хэрэглэх нөхцөлөөр олгох татаас²⁴ (import substitution subsidy)²⁵ юм. Ийн хориглосон татаас нь хууль, практикын аль ч хэлбэрээр байж болно. Тус хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад хориглосон [экспортын] татаасын дэлгэрэнгүй жагсаалтыг оруулсан.²⁶ Эдгээр хоёр төрлийн татаасыг бусад улстай хийх худалдааны ашиг сонирхолд хамгийн их сөрөг нөлөө үзүүлэх боломжтой гэж үздэг учраас ерөнхийдөө зөвшөөрдөггүй. Гэхдээ экспортын татаасыг ДХБ-ын Хөдөө аж ахуйн хэлэлцээрт өөрөөр заасан тохиолдолд хэрэглэж болно (энэ талаар дор байгаа “Хөдөө аж ахуйн татаас” хэсгээс үз). Экспортын татаас гэдэгт энд дээр дурдсан нарийсан агуулга бүхий тодорхойлолтод хамаарах (экспортын гүйцэтгэлийг хангах болзолтой) татаасыг ойлгож буйг анхаарна уу.

“Actionable” татаас. Үйлдвэрлэлийн татаас зэрэг ихэнх татаас энэ ангилалд хамаарах бөгөөд шууд хориглодоггүй. Гэхдээ ийм төрлийн татаас нь өөр нэгэн гишүүн улсын ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлсэн бол ДХБ-ын маргаан шийдвэрлэх механизмаар дамжуулан гомдол гаргах эсхүл саармагжуулах арга хэмжээ авах боломжтой. Сөрөг нөлөө үзүүлсэн гэдгийг гомдол гаргаж буй улс нотлох үүрэгтэй.

Сөрөг нөлөө нь гурван төрөл байна. Нэгдүгээрт татаас бүхий импортын улмаас гомдол гаргаж буй гишүүний нутаг дэвсгэрт түүний дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан байх, хоёрдугаарт 1994 оны ТХЕХ-ийн дагуу бусад гишүүнд шууд болон шууд бусаар хуримтлагдсан ашгийг хүчингүй болгосон эсхүл бууруулсан байх, гуравдугаарт нөгөө гишүүний ашиг сонирхолд ноцтой хор хөнөөлтэй эсхүл тийм хор хөнөөл учруулж болохуйц байх. Дотоодын үйлдвэрлэлд хохирол учруулах тухай ойлголт нь бодит/материаллаг хохирол учруулснаас гадна ийм хохирол учруулж болзошгүй байдал болон дотоодын үйлдвэрлэлийг бий болгоход материаллаг саад бий болгох зэргийг хамарна. Ноцтой хор хөнөөл нь өөр нэгэн гишүүний импортыг татаастай гишүүний зах зээл эсхүл гуравдагч улсын зах зээл рүү шилжүүлэх эсхүл тэдгээрт нэвтрэхэд саад хийх зэрэг сөрөг нөлөөний үр дүн байдлаар тодорхойлогдоно.²⁷

²³ Татаас болон саармагжуулах арга хэмжээний хэлэлцээр, 3.1 (a)

²⁴ Татаас болон саармагжуулах арга хэмжээний хэлэлцээр, 3.1 (b)

²⁵ Импортыг орлох татаасыг өөрөөр “дотоодын агуулга бүхий татаас” гэж нэрлэдэг.

²⁶ Дэлгэрэнгүйг https://www.wto.org/english/docs_e/legal_e/24-scm.pdf -аас үзнэ үү.

²⁷ Peter Van den Bossche and Werner Zdouc, *The Law and Policy of the World Trade Organization: Text, Cases and Materials* (Cambridge: Cambridge University Press,

Монгол Улсын ДХБ-ын өмнө хүлээсэн амлалт. Монгол улс ДХБ-д элсэн ороходоо татаасын тухайд дараах тусгай үүрэг амлалт өгчээ. Үүнд:

23. “Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн агуулгын хүрээнд хориглосон татаасын тодорхойлолтод нийцэж байгаа арга хэмжээг, өөрөөр хэлбэл 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу олгож байгаа татаасыг Засгийн газар нь 2002 оны 12 дугаар сарын 31-ний дотор болж өгвөл шатлан гүнзгийрүүлэх аргаар бүрмөсөн цуцлах талаар Монголын төлөөлөгч үүрэг авав. [нэ нь] ... уул уурхай, метал боловсруулах, машин байгууламж болон дэд бүтцийн салбарт оруулсан гадаадын хөрөнгө оруулалтад (i) 5-аас дээш 10 хүртэл жилд татвараас хэсэгчлэн болон бүрэн чөлөөлөх; (ii) бүтээгдэхүүнийхээ 50-аас дээш хувийг экспортолж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрт эхний 3 жилд татаасын хөнгөлөлт үзүүлж байсан.”²⁸

Энэ тухай 2021 оны Монгол улсын Худалдааны бодлогыг хянан үзэх тухай ДХБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын тайлан (Mongolia’s Trade Policy Review Report by WTO Secretariat)-д “2004 оноос хойш Монгол Улс ТХЕХ-ийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 25 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл хийгээгүй. Хамгийн сүүлд 2000 оны 4 дүгээр сард хийсэн мэдэгдэлдээ Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн 2 дугаарын зүйлд тусгайлан хамаарах тус хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга бүхий шууд болон шууд бусаар экспортыг нэмэгдүүлэн импортыг бууруулахад чиглэсэн татаас байхгүй хэмээн мэдэгдсэн”²⁹ хэмээн дурджээ. Эндээс үзвэл Монгол Улс нэгдэн орох үедээ

Хөдөө аж ахуйн татаас. Хөдөө аж ахуйн татаасын асуудал олон улсын худалдаанд ихээхэн маргаантай байж ирсэн, тухайлбал Уругвайн болон Дохагийн хөгжлийн үе шатны хэлэлцээрийн гол асуудал байсан. Хөдөө аж ахуйн экспортын татаас, дотоодын хөдөө аж ахуйн салбарыг дэмжих арга хэмжээ нь ДХБ-ын гишүүн хөгжиж буй орны хөдөө аж ахуйн бодлогын зайлшгүй чухал хэрэгсэлд тооцогддог. Гэхдээ хөдөө аж ахуйн татаас нь ДХБ-ын бусад олон гишүүний худалдааны ашиг сонирхол, эдийн засгийн хөгжилд ноцтой сөрөг

2017), pp.878-879

²⁸ Монгол Улс ДХБ-д нэгдэн орох асуудлаарх ажлын хэсгийн илтгэл (“ДХБ дахь Монгол улс: Албан ёсны баримт бичгүүдийн эмхтгэл”, 2 дахь хэвлэл, УБ.,2003, 39 дэх тал)

²⁹ Mongolia’s Trade Policy Review Report by the WTO Secretariat (1 January 2021) https://www.wto.org/english/tratop_e/tpr_e/s406_e.pdf

нөлөө үзүүлж болзошгүй бөгөөд ялангуяа хөгжингүй орны хөдөө аж ахуйн татаасын үр нөлөө хөгжиж буй оронд хүнд тусах эрсдэлтэй. Хөдөө аж ахуйн татаасын асуудалд Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр бүрэн үйлчлэхгүй бөгөөд ДХБ-ын Хөдөө аж ахуйн хэлэлцээр (WTO Agreement on Agriculture) нь хөдөө аж ахуйн экспортын татаасыг тусгайлан зохицуулсан. Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр дэх татааст хамаарах ерөнхий зохицуулалттай Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн зохицуулалт зөрчилдвөл тусгай зохицуулалт бүхий гэдгээрээ Хөдөө аж ахуйн хэлэлцээр давуу хүчинтэйд тооцогдоно.³⁰ Хөдөө аж ахуйн бус бүтээгдэхүүнд экспортын татаас хэрэглэхийг хориглодог (Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрт энэ тухай заасан тухай өмнө өгүүлсэн) ч хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд экспортын татаасын тухайд (i) ДХБ-ын гишүүний ТХЕХ-ийн тарифын буултын жагсаалтын 4 дүгээр хэсгийн 2 дахь дэд хэсэгт заасан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон (ii) мөн дэд хэсэгт тусгайлан заагаагүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хооронд ялгаатай.³¹ Хэрэв ТХЕХ-ийн тарифын буултын жагсаалтын 4 дүгээр хэсгийн 2 дахь дэд хэсэгт тодорхой хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дурдсан бол энэ нь тэдгээр бүтээгдэхүүнд экспортын татаас хэрэглэхийг хориглоогүй боловч татаасыг бууруулах үүрэг амлалт авсан гэсэн үг бөгөөд ингэхдээ жагсаалтад заасан төсвийн санхүүжилт, тоон хязгаарлалтын түвшингээс хэтрүүлэхгүйгээр тэдгээр бүтээгдэхүүнийг экспортын татаасаар дэмжиж болно.

Харин ДХБ-ын гишүүний ТХЕХ-ийн тарифын буултын жагсаалтын 4 дүгээр хэсгийн 2 дахь дэд хэсэгт заагаагүй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хувьд ДХБ-ын гишүүн экспортын татаас олгох эрхгүй. Монгол Улсын Тарифын буултын жагсаалтын тус дэд хэсэгт ямар нэгэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дурдаагүй байна. Үүнийг тухайн үед Монгол улс аливаа хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд экспортын татаас олгож байгаагүй учраас энэ хэсэгт ямар нэгэн үүрэг амлалт аваагүй гэж тайлбарлаж болох талтай. Учир нь улс орнууд ДХБ-д нэгдэн орох үедээ хэрэглэж буй экспортын татаасаа тодорхой хэмжээнд хадгалах үүднээс ТХЕХ-ийн тарифын буултын жагсаалтын 4 дүгээр хэсгийн 2 дахь дэд хэсэгт үүрэг амлалт өгдөг хэмээн үзэж болох юм. Харин Тарифын буултын жагсаалтын 29 дэх хуудсанд Монгол улс экспортын татаасын тухайд дотоодын дэмжлэг нь “de minimis level” байна гэж тэмдэглэжээ.³² *De minimis* нь хөгжингүй

³⁰ Хөдөө аж ахуйн хэлэлцээрийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг

³¹ Peter Van den Bossche and Werner Zdouc, *The Law and Policy of the World Trade Organization: Text, Cases and Materials* (Cambridge: Cambridge University Press, 2017), p.869

³² Mongolia's Goods Schedule (Schedule of Concessions and Commitments Annexed to

орны хувьд үйлдвэрлэлийн өртгийн 5 хувь, хөгжиж буй орны хувьд 10 хувь хүртэл байдаг.³³

III. Зарим гадаад улсын туршлага, харьцуулалт

Оршил хэсэгт дурдсанчлан дор судлан буй улсуудын ихэнх нь Монгол Улсын худалдааны гол түншүүд бөгөөд эдгээр улсын худалдааны зохицуулалтыг судлах нь тэдгээртэй үр ашигтай худалдаа хийхэд чухал эхлэлийн цэг байх болно. Энэтхэг улсын тухайд Монгол улстай улс төр, эдийн засгийн харилцааг идэвхтэй өрнүүлж буй бөгөөд ирээдүйд Монгол улсын худалдааны нэг гол түнш болох төлөвтэй. Мөн Энэтхэг улс нь ДХБ-ын гишүүдийн дотор экспорт, импортын тэнцвэрийг хадгалсан гадаад худалдааны бодлогыг амжилттай хэрэгжүүлж буй улсуудын нэг юм. Энэ хэсгийн судалгаа нь судлан буй гадаад улсууд худалдааны бие даасан хуультай эсэх асуудалд голлон анхаарсан бөгөөд худалдааны бодлого, худалдааны хамгаалалтын арга хэрэгслийн талаар онцлоогүй болно.

3.1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ нь Гадаад худалдааны хууль (Foreign Trade Law, 中华人民共和国对外贸易法)-ийг 1994 онд баталсан. Тус хууль нь 11 бүлэг, 70 зүйлтэй.³⁴ Гадаад худалдааг хөгжүүлэх, гадаад худалдааны дэг журмыг сахиулах, гадаад худалдааны эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, социалист зах зээлийн эдийн засгийн зохистой хөгжлийг дэмжих зорилготой.³⁵ Гадаад худалдаа, түүнтэй холбоотой оюуны өмчийн эрхийн хамгаалалтын асуудлыг зохицуулсан.³⁶

Хуульд тодорхойлсноор гадаад худалдаа гэдэгт импортын болон экспортын бараа, технологийн худалдаа, үйлчилгээний худалдаа хамаарна.³⁷ Төрийн Зөвлөлийн дэргэдэх Гадаад худалдааны газар нь улс даяарх гадаад худалдааны асуудлыг хариуцна. БНХАУ нь гадаад худалдааны чиглэлд нэгдсэн тогтолцоо хэрэгжүүлнэ. Хуульд зааснаар БНХАУ нь бусад улс, бүс нутагтай худалдааны асуудлаар харилцахдаа, бүс нутгийн эдийн засгийн болон худалдааны гэрээ байгуулах, чөлөөт бүсийн хэлэлцээрт нэгдэх, бүс нутгийн эдийн засгийн байгууллагад элсэхдээ харилцан эрх тэгш, ашигтай байх зарчмыг баримтална. Мөн БНХАУ гарын үсэг зурсан, нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу гэрээлэгч бусад талуудад

the GATT 1994) <https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=Q:/WT/ACC/MNG9A1-03.pdf&Open=True>

³³ https://www.wto.org/english/thewto_e/glossary_e/de_minimis_e.htm

³⁴ Foreign Trade Law of The People's Republic of China https://english.www.gov.cn/archive/laws_regulations/2014/08/23/content_281474982987386.htm

³⁵ БНХАУ-ын Гадаад худалдааны хууль, 1 дүгээр зүйл

³⁶ Мөн тэнд, 2 дугаар зүйл

³⁷ Мөн тэнд, 3 дугаар зүйл

харилцан ашигтай байх зарчмын үүднээс үндэсний нэн таатай нөхцөл, үндэсний нөхцөл олгох зохицуулалттай.

Харин БНХАУ-ын эсрэг хориглосон, хязгаарласан болон ялгаварлан гадуурхсан шинж бүхий тэдгээртэй төстэй бусад арга хэмжээг аливаа улс, бүс нутаг авсан тохиолдолд бодит нөхцөл байдлын үүднээс тухайн улс, бүс нутгийн эсрэг хариу арга хэмжээг зохих ёсоор авах талаар мөн тус хуульд тусгасан байна.³⁸ Сүүлийн үеийн мэдээгээр тус хуульд 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Ардын их хурлын шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт, өөрчлөлтөөр гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэгчдийн мэдүүлэг гаргах, бүртгэхтэй холбоотой асуудлыг зохицуулсан 9 дүгээр зүйлийг хүчингүй болгожээ.³⁹

3.2 Оросын Холбооны Улс

2003 онд Төрийн Дум Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулахад баримтлах үндсэн зарчмуудын тухай Холбооны хууль (Federal Law On Basic Principles of State Regulation of Foreign Trade Activity (Федеральный закон «Об основах государственного регулирования внешнеторговой деятельности, 2003»)-ийг баталжээ.⁴⁰ 13 бүлэг, 54 зүйлтэй. Уг хуульд 2023 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.⁴¹ Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулахад баримтлах үндсэн зарчим, гадаад худалдааны үйл ажиллагаанд таатай нөхцөлийг бүрдүүлэх болон ОХУ-ын эдийн засаг, улс төрийн ашиг сонирхлыг хамаагалах чиглэлд ОХУ болон түүнийг бүрдүүлэгч субъектүүдийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлсон.⁴²

Дээрх зохицуулалтаас гадна 2009 онд Төрийн Дум нь Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах үндсэн зарчмуудын тухай хууль (Об основах государственного регулирования торговой деятельности в Российской Федерации) гэх тусгайлсан эрх зүйн актыг батлажээ.⁴³ Энэ нь үндсэндээ тус улсын дотоод дахь худалдааны үйл ажиллагаанд хамаарах бөгөөд гадаад худалдааны үйл ажиллагаа хэрэглэгдэхгүй.⁴⁴

³⁸ Мөн тэнд, 6, 7 дугаар зүйл

³⁹ Foreign trade law revised to optimize business environment http://en.npc.gov.cn.cdurl.cn/2023-02/14/c_909612.htm

⁴⁰ Федеральный закон от 08.12.2003 г. № 164-ФЗ • Президент России <http://kremlin.ru/acts/bank/20277>

⁴¹ Amendments to laws on customs tariffs and on basic principles of state regulation of foreign trade activity • President of Russia <http://en.kremlin.ru/acts/news/73120>

⁴² Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулахад баримтлах үндсэн зарчмуудын тухай Холбооны хууль, 1 дүгээр зүйл

⁴³ Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах үндсэн зарчмуудын тухай хууль/Федеральный закон об основах государственного регулирования торговой деятельности в Российской Федерации <http://government.ru/docs/all/99391/>

⁴⁴ Мөн тэнд, 1 дүгээр зүйл. Түүнчлэн барааны бирж дээрх худалдаа, жижиглэнгийн зах зээл дээрх худалдаа, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө, үйлдвэрлэлийн зориулалттай

Хууль нь дараах зорилготой. Үүнд:

а) ОХУ-ын эдийн засгийн орон зайг нэгтгэх, худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх шаардлагыг тогтоох;

б) худалдааны үйл ажиллагааг хөгжүүлэх, эдийн засгийн салбаруудын хэрэгцээг хангах, хүн амд бараа бүтээгдэхүүний хүртээмжийг хангах, өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх, Оросын үйлдвэрлэгчдийг дэмжих;

в) Худалдааны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн болон бараа бүтээгдэхүүн нийлүүлдэг аж ахуйн нэгжүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, эдгээр аж ахуйн нэгжүүдийн эдийн засгийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангах, хүн амын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

д) Худалдааны үйл ажиллагааг зохицуулахад холбооны төрийн эрх бүхий байгууллагууд, ОХУ-ын субъектуудын төрийн эрх бүхий байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын эрх хэмжээг тодорхойлох.⁴⁵

ОХУ-ын нутаг дэвсгэр дээр тус улсын төрийн эрх бүхий байгууллагууд, орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд болон худалдааны аж ахуйн нэгжүүдийн хоорондын худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.⁴⁶

Худалдааны үйл ажиллагааны төрийн зохицуулалтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

а) худалдааны үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх шаардлагыг тогтоох;

б) өрсөлдөөний зохицуулалт хийх;

в) мэдээллийн дэмжлэг үзүүлэх;

д) төрийн болон орон нутгийн хяналт хийх.⁴⁷

ОХУ-ын Засгийн газар нь худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах чиглэлээр дараах эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а) Худалдааны үйл ажиллагааны талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;

б) ОХУ-ын субъектуудын худалдааны талбайн нормативыг тогтоох аргачлал, журмыг батлах;

бүтээгдэхүүн (цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч болон бусад төрлийн эрчим хүчний нөөц) худалдах, худалдан авах үйл ажиллагаанд хэрэглэгдэхгүй.

⁴⁵ Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах үндсэн зарчмуудын тухай хууль, 1 дүгээр зүйл

⁴⁶ Мөн тэнд.

⁴⁷ Мөн тэнд, 4 дүгээр зүйл

с) ОХУ-ын субъектуудын, түүний дотор Москва, Санкт-Петербург, Севастополь хотуудын, мөн орон нутгийн дүүрэг, орон нутгийн тойрог, хотын тойргийн хил хязгаарт хүнсний бүх бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээг мөнгөн дүнгээр тооцох аргачлал, журмыг батлах, мөн худалдааны сүлжээгээр хүнсний бүтээгдэхүүн борлуулдаг аж ахуйн нэгжийн борлуулалтын нийт хэмжээг тодорхойлох аргачлал, журмыг батлах г.м.⁴⁸

3.3 Япон Улс

Япон Улс Гадаад гүйлгээ, гадаад худалдааны хууль (Foreign Exchange and Foreign Trade Law)-ийг 1949 онд баталжээ.⁴⁹ Хууль нь 11 бүлэг, 124 зүйлтэй. Уг хуульд зааснаас бусад тохиолдолд буюу гадаад худалдаа болон үндэсний эрх ашгийг хамгаалахын тулд зөвшөөрөл авах шаардлагатайгаас бусад үед ихэнх барааг чөлөөтэй импортлох боломжтой. Гадаад гүйлгээ, төлбөр, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад худалдааг зохицуулсан.⁵⁰

2017 онд зэвсэг импортлох, экспортлох, тэр дундаа технологи дамжуулахтай холбоотой зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгасан нэмэлт, өөрчлөлтийг тус хуульд оруулжээ. Торгуулийн хэмжээ өмнөх 7 сая ¥ байсан бол 700 сая ¥ буюу импорт/экспортын үнээс тав дахин нэмэгджээ.⁵¹

3.4 Бүгд Найрамдах Солонгос Улс

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Гадаад худалдааны хууль (Foreign Trade Act)-ийг 2016 онд баталсан. 7 бүлэг, 59 зүйлтэй.⁵² Өмнө нь 1956, 1986 онуудад Гадаад худалдааны хууль тус тус баталж байжээ.⁵³

Хууль нь гадаад худалдааг дэмжих, шударга худалдааны тогтолцоог бүрдүүлэх, олон улсын төлбөрийн тэнцлийг хадгалах, худалдааг өргөжүүлэх замаар үндэсний эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах зорилготой.

3.5 Бүгд Найрамдах Энэтхэг Улс

Эдүгээ 1992 онд баталсан Гадаад худалдааны хөгжил,

⁴⁸ Мөн тэнд, 5 дугаар зүйл

⁴⁹ Foreign Exchange and Foreign Trade Act - English - Japanese Law Translation <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/21/en>

⁵⁰ Гадаад гүйлгээ, гадаад худалдааны тухай хууль, 1 дүгээр зүйл

⁵¹ Import & Export in Japan (2023): Trade Policies & Regulation - OOSGA <https://oosga.com/briefings/jpn-trade-policies/>

⁵² Foreign Trade Act https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37529&lang=ENG

⁵³ Eun Sup Lee, "Regulation of International Trade in Korea under the WTO Mechanism" <https://www.wgtn.ac.nz/law/research/publications/about-nzacl/publications/nzacl-yearbooks/yearbook-3,-1997/Lee.pdf>.

зохицуулалтын тухай хууль (The Foreign Trade Development and Regulation Act) үйлчилж байна. 6 бүлэг, 20 зүйлтэй.⁵⁴

Хуулиар импорт, экспортын бараанд хориг тавих, хязгаарлах, өөр бусад байдлаар зохицуулах эрхийг засгийн газарт олгожээ. Тус хуулийн хүрээнд гадаад Гадаад худалдааны үзэл баримтлал (Foreign Trade Policy (FTP)) гэх бодлогын баримт бичиг баталсан. Уг баримт бичгийг хамгийн сүүлд 2023 онд шинэчлэн боловсруулсан байна.⁵⁵

Хүснэгт. БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, Энэтхэг улсуудын гадаад худалдааны хуулийн харьцуулалт (бүлгээр)

Бүлгийн дугаар	БНХАУ	ОХУ	Япон	БНСУ	Энэтхэг
	Гадаад худалдааны хууль (Foreign Trade Law, 1994)	Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулахад баримтлах үндсэн зарчмуудын тухай Холбооны хууль (Федеральный закон «Об основах государственного регулирования внешнеторговой деятельности, 2003)	Гадаад гүйлгээ, гадаад худалдааны хууль (Foreign Exchange and Foreign Trade Law, 1997)	Гадаад худалдааны хууль (Foreign Trade Act, 2007, 2016)	Гадаад худалдаа (хөгжил ба зохицуулалт)-ны тухай хууль (Foreign Trade (development and regulation) Act, 1992)
1-р бүлэг	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл	Нийтлэг үндэслэл (1-9 дүгээр зүйл)	Нийтлэг үндэслэл	Удиртгал
2-р бүлэг	Гадаад худалдаа	Гадаад худалдааны	Японд энх тайван,	Олон улсын	Гадаад худалдаа-

⁵⁴ India Code: Foreign Trade (Development and Regulation) Act, 1992 https://www.indiacode.nic.in/handle/123456789/1947?sam_handle=123456789/1362

⁵⁵ Press Release: Press Information Bureau <https://pib.gov.in/PressReleaseIframePage.aspx?PRID=1912572>

	эрхлэгч	үйл ажиллагаа дахь Холбооны гүйцэтгэх байгууллага, ОХУ-ын субъектүүдийн төрийн эрх бүхий байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээ	аюулгүй байдлыг сахиулах зорилгоор авах арга хэмжээ (10-15 дугаар зүйл)	худалдааг дэмжих	ны бодлогын талаар шийдвэр гаргах, түүнийг зарлах төв засгийн газрын бүрэн эрх
3-р бүлэг	Барааны импорт, экспорт ба технологи	Гадаад худалдааны үйл ажиллагаанд оролцогч этгээд	Төлбөр төлөх, хүлээн авах (16-19 дүгээр зүйл)	Экспорт, импорт	Импорт-логч-Экспорт-логчийн кодын дугаар, лиценз
					ША Тоон хязгаарлалт
4-р бүлэг	Олон улсын үйлчилгээний худалдаа	Гадаад худалдааг төрөөс зохицуулах суурь үндэслэл	Хөрөнгийн гүйлгээ; Бусад асуудал Capital Transactions; Related Matters (20-оос 25-2 дугаар зүйл)	Импортын тоо хэмжээнд тавих хяналт	Нэгжих, хураах, торгох, нөхөн төлбөр авах
					IVA Тусгай бараа, үйлчилгээ, технологийн экспортод тавих хяналт
5-р бүлэг	Гадаад худалдаанд хамаарах оюуны өмчийн эрх	Барааны гадаад худалдааны чиглэлд гадаад худалдааг төрөөс зохицуулах	Шууд хөрөнгө оруулалт ба түүнтэй адилтгах арга хэмжээ (26-46 дугаар зүйл)	Экспорт, импортын барааны захиалга	Давж заалдах ба Гомдол гаргах
6-р бүлэг	Гадаад худалдааны	Үйлчилгээний гадаад худалдааны	Гадаад худалдаа (47-54)	Нэмэлт заалт	Бусад

	захиалга	чиглэлд гадаад худалдааг төрөөс зохицуулах	дүгээр зүйл) Бүлэг VI-2. Тайлагнал, бусад асуудал (55-аас 55-9 дүгээр зүйл)		
			Бүлэг VI-3. Экспортлогч болон ижил төстэй ажил үйлчилгээ эрхэлж буй этгээдийн дагаж мөрдөх стандарт (55-10-аас 55-12 дугаар зүйл)		
7-р бүлэг	Гадаад худалдааны магадлан шалгалт (investigation)	Оюуны өмчийн гадаад худалдааны чиглэлд гадаад худалдааг төрөөс зохицуулах	VII. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуультай холбогдох (55-13 дугаар зүйл)	Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага	
			VII-2. Хяналт хийлгэх хүсэлт (56-64 дүгээр зүйл)		
8-р бүлэг	Гадаад худалдааны хамгаалалтын арга хэрэгсэл	Бараа, үйлчилгээ, оюуны өмчийн гадаад худалдаанд тавих хориг хязгаарлалтын тусгай төрөл,	Бусад зүйл (65 - 69-5 дугаар зүйл)		
9-р бүлэг	Гадаад худалдааг дэмжих (promo-	Гадаад худалдааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Эрүүгийн хариуцлагын заалт (69-6-аас 73 дугаар зүйл)		

	-tion of foreign trade)	тусгай дэглэм			
10-р бүлэг	Хууль зүйн хариуцлага	Гадаад худалдааны бартерийн гэрээг төрөөс зохицуулах (State Regulation of Foreign Trade Barter Transactions)			
11-р бүлэг	Нэмэлт зүйл	Гадаад худалдааны үйл ажиллагааг дэмжих (Promotion of Foreign Trade Activity)			
12-р бүлэг		Гадаад худалдааны үйл ажиллагаа эрхлэхэд тавих хяналт, гадаад худалдааны үйл ажиллагааны талаарх ОХУ-ын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага			
13-р бүлэг		Төгсгөлийн болон шилжилтийн заалтууд			

IV. Монгол Улсын Худалдааны хуулийн хамрах хүрээ, зохицуулах асуудлыг тодорхойлох нь

4.1 Хуулийн хэрэгцээ, шаардлага

Монгол Улс ДХБ-ыг үүсгэн байгуулах тухай Марракешийн хэлэлцээр, түүний хавсралтад заасан олон талт гэрээнүүд нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу Монгол Улсын

олон улсын гэрээ болох ба энэ нь мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар эрх зүйн хүчин чадлын хувьд дотоодын хуультай ижил. Эндээс дотоодын хуулийн адил үйлчлэх хүчин чадалтайд тооцогдох ДХБ-ын хэлэлцээрүүдийг дотоодод шууд мөрдөх нь хангалттай юу эсхүл эдгээр хэлэлцээрийг дотоодын эрх зүйн актууд (хуулийг оролцуулаад)-аар илүү нарийвчлах шаардлагатай юу гэх асуудал гарч ирнэ.

Импорт, экспортын татвар, экспортын татаасын талаарх ДХБ-ын зохицуулалт нь гишүүддээ тодорхой орон зай, боломж олгодгийг 1 дүгээр бүлэгт авч үзсэн. Өөрөөр хэлбэл ийм орон зай, боломжийг гишүүд ашиглан дотоодын зохицуулалтаа боловсруулдаг.

2 дугаар бүлэгт БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, Энэтхэг улсуудын худалдааны зохицуулалтыг судалсан. Эдгээр улс “гадаад” худалдааны хуультай байна. Өөрөөр хэлбэл эдгээр улсуудын төрийн бодлого нь гадаад худалдааг өөр өөр хуулиудад зүйл, заалт шигтгэх замаар бус нэг талаас тусгайлсан, нөгөө талаас нэгдсэн байдлаар зохицуулах байдлаар хэрэгжиж байна. Монгол Улс энэ жишгийг харгалзан гадаад худалдааны бие даасан хуультай болох нь тэдгээртэй нэгдсэн бодлогоор харилцахад дөхөм үзүүлнэ. Нөгөө талаас худалдааны зохицуулалтын ил тод байдлыг хангана.

Харин “дотоод” худалдаанд төрөөс баримтлах бодлогыг тодорхойлсон тусдаа хууль байх хэрэгтэй эсэх тухайд зах зээлийн чиг баримжаатай улсуудад үүнийг *ерөнхийлөн нэг хуульд тусгах гэхээсээ* үндэсний эдийн засгийн онцлог, дотоодын үйлдвэрийн хөгжил, өрсөлдөх чадвар зэргийг харгалзан *аль салбарт шударга өрсөлдөөнийг дэмжиж нээлттэй бодлого баримтлах, аль салбарт дотоодын аж ахуй эрхлэгчдийг хамгаалах бодлого хэрэгжүүлэхээ салбар бүрт тусгайлан авч үзсэн шинжтэй байдаг*. Харин ОХУ-ын тухайд дотоод худалдаандаа төрийн зохицуулалт нь нийтлэг байдлаар “... Оросын үйлдвэрлэгчдийг дэмжих”-д чиглэсэн байхаар хуульчилсан байна. Ингэснээр үүнд худалдааны олон төрлийн салбарын хууль тогтоомж нийцсэн байх үндсийг тогтоосон гэж үзэж болохуйц юм.

4.2 Хуулийн хамрах хүрээ, зохицуулах асуудал

Хэрэв Монгол Улс худалдааны хуультай байх тохиолдолд уг хууль ямар асуудлыг өөртөө багтаах буюу хуулийн хамрах хүрээг хэрхэн тодорхойлох вэ гэх асуулт яригдах нь зүй. Энэ тухайд дараах зүйл яригдана. Үүнд:

Нэгдүгээрт, Худалдааны хууль (Trade Law) нь юун түрүүнд “гадаад” худалдааны асуудлыг хамарсан байх нь тодорхой. Энэ тухайд Монгол Улсын олон улсын гэрээ болох ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд Монгол Улс худалдааны бодлогоо боловсруулж үүний дагуу зохицуулалтаа тодорхойлох шаардлагатай. Энэ талаар, тухайлбал, 1

дүгээр бүлгийн 2 дахь хэсэгт импорт, экспортын татвар, экспортын татаасын талаарх ДХБ-ын зохицуулалтын хүрээнд ДХБ-ын гишүүнд дотоодын зохицуулалтаа боловсруулахад ямар хязгаарлалт хийгээд боломж байгааг судалсан. Тодруулбал ДХБ-ын хэлэлцээр бүрт олон улсын худалдаанд гишүүн улсад ямар эрх олгож, үүрэг хүлээлгэж буйг сайтар ойлгож дотоодын зохицуулалтаар нарийвчлах, зохицуулах ямар орон зайг тогтоох нь ирээдүйд үүсэж мэдэх зөрчлөөс сэргийлэхэд тустай. Мөн ДХБ-д нэгдэн орсон протоколоор ямар нэгэн хязгаарлалт байгаа эсэхийг шалгах шаардлагатай. Энэ талаар тус хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн. Гадаад худалдааны асуудлыг бараа, үйлчилгээ, оюуны өмч гэсэн ДХБ-аас зохицуулдаг худалдааны гурван үндсэн салбарт тухайн улсын төрөөс ямар бодлого баримтлахыг нэгдсэн байдлаар хамарсан шинжтэй болох нь харьцуулсан судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хоёрдугаарт, Худалдааны хууль гадаад, дотоод худалдааг хамтад нь зохицуулах уу гэдэг асуулт байна. 2 дугаар бүлэгт судалсан гадаад улсуудын тухайд гадаад худалдааг нэгдмэл байдлаар тусдаа хуулиар зохицуулж буй нь нийтлэг бол дотоод худалдааг үүнтэй ижил хэв маягаар бус, харин өөр өөр хууль, бусад эрх зүйн актаар зохицуулж байна. Өөрөөр хэлбэл харьцуулсан судалсан улсуудад худалдааны хууль нь гадаад, дотоод худалдааг нэгэн дор буюу хамтад нь гэхээсээ гадаад худалдааны төрийн бодлогын үндсийг тодорхойлоход чиглэсэн нь түгээмэл байна. Дотоодын худалдаа, түүний дотор сүүлийн жилүүдэд CU, GS25 зэрэг гадаадын ая тухтай дэлгүүр (convenience store) манай улсад олноор нээгдэн үйл ажиллагаа явуулж буйтай холбоотойгоор жижиглэн худалдааны асуудлыг хэрхэн зохицуулвал болох вэ гэх яриа идэвхтэй өрнөж байна. Тэгвэл уг асуудлыг энэ хуулиар зохицуулах боломжтой юу? Энэ асуудал нь юун түрүүнд гадаадын хөрөнгө оруулалт болон өрсөлдөөний зохицуулалтад хамаарах боломжтой. Энэ судалгаанд авч үзсэн гадаад улсуудад (Японоос бусад (хуулийн 26-46 дугаар зүйл)) гадаад худалдааны хууль гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг шууд хамраагүй (2 дугаар бүлэг дэх харьцуулсан хүснэгт үз). Гэхдээ худалдаанд хамаарах хөрөнгө оруулалтын арга хэмжээ (trade-related investment measures) нь ДХБ-ын/олон улсын худалдааны зохицуулалтын хүрээнд багтдаг тул дээрх асуудлыг худалдааны хуулийн зохицуулалтаас ангид байна гэж шууд дүгнэхгүй. Энэ асуудлыг нэг талаас худалдааны зохицуулалт, нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулалт, өрсөлдөөний хууль тогтоомжийн холбоо хамаарал, зааг хязгаарын хүрээнд тусгайлан судлах шаардлагатай.

V. Дүгнэлт

1. Монгол Улсад худалдааг хуулиар хэрхэн зохицуулах асуудал судалгааны нээлттэй сэдэв хэвээр байгааг харгалзан энэ өгүүллийг бичсэн бөгөөд судалгаанаас гарч буй шууд үр дүнг танилцуулбал юуны түрүүнд Монгол Улсын худалдааны гол түншүүд [гадаад] худалдааг тусдаа хуулиар зохицуулж байна. 2 дугаар бүлэгт БНХАУ, ОХУ, Япон, БНСУ улсуудын худалдааны зохицуулалтыг тусгайлан авч үзсэн. Эдгээр улс “гадаад” худалдааны хуультай буюу төрийн бодлого нь гадаад худалдааг өөр өөр хуулиудад зүйл, заалт шигтгэх замаар бус нэг талаас тусгайлсан, нөгөө талаас нэгдсэн байдлаар зохицуулах байдлаар хэрэгжиж байна. Тиймээс Монгол Улс энэ жишгийг харгалзаж гадаад худалдааны бие даасан хуультай болох нь олон улсын худалдаанд үндэсний ашиг сонирхлыг хангаж, тэдгээр улстай нэгдсэн бодлогоор харилцахад дэм болно.

2. Гадаад худалдааг олон улсын түвшинд ДХБ зохицуулдаг бөгөөд Монгол Улс нь ДХБ-ын гишүүн, ДХБ-ын хэлэлцээрүүд нь Монгол Улсын шударгаар сахин биелүүлэхээр амлалт өгсөн олон улсын гэрээ юм. Иймд ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд Монгол Улс худалдааны бодлогоо боловсруулж зохицуулалтаа тодорхойлох нь олон улсын худалдааны дүрмээр дэлхийн улсуудтай худалдаа хийж үр ашиг хүртэх, түүнээс үүсэх эрсдэл, эрх зүйн асуудлыг зүй ёсоор зохицуулахад амин чухал. Энэ тухайд ДХБ нь гишүүддээ ямар “regulatory space” буюу зохицуулалтын орон зай олгодгийг, тодруулбал ДХБ-ын хэлэлцээр бүрт гишүүн улсад ямар эрх олгож, үүрэг хүлээлгэж буйг сайтар ойлгож дотоодын зохицуулалтаар нарийвчлах, зохицуулах орон зайг тогтоох шаардлагатай. Жишээлбэл худалдааны бодлогын хууль ёсны арга хэрэгсэлд тооцогддог экспорт, импортын татвар хийгээд экспортын татаасын тухайд ДХБ-ын холбогдох бодлого, зохицуулалт юу болох, Монгол Улсад ямар хязгаарлалт, бас боломж байгааг тухайлан энэ судалгаанд авч үзсэнээс товч хураангуйлбал:

А. Монгол Улсын хувьд ДХБ-д нэгдэн орохдоо импортын тарифын түвшинг ихэнх бараанд үнийн дүнгийн 20 хувиас хэтрүүлэхгүй байх үүрэг хүлээсэн.

В. ДХБ-ын гишүүн тус байгууллагад нэгдэн орохдоо экспортын татварын үүрэг тусгайлан хүлээснээс бусад тохиолдолд экспортын татвар хэрэглэх эсэх нь тухайн гишүүний бүрэн эрх байдаг. Монгол Улсын хувьд түүхий ноолуураас бусдаар экспортын татвар ногдуулах эрх хязгаарлагдаагүй.

С. Хөдөө аж ахуйн хэлэлцээрээр зөвшөөрсөн экспортын татаасын тухайд Монгол Улс ДХБ-д нэгдэн орохдоо ТХЕХ-ийн дагуу хийсэн

тарифын буултын жагсаалтдаа ямар бүтээгдэхүүнийг *экспортын* татаасаар хэрхэн дэмжих талаар тусгаагүй. Ийм нөхцөлд хөгжиж буй оронд олгох “тусгай, хөнгөлөлттэй дэглэм”(special and differential treatment) хэрэгжиж байгаагаас бусад тохиолдолд экспортын татаас хэрэглэх эрх хязгаарлагддаг.

3. Худалдааны хууль нь гадаад, дотоод худалдааг нэгэн дор буюу хамтад нь гэхээсээ гадаад худалдааны төрийн бодлогын үндсийг тусдаа хуулиар тодорхойлох нь харьцуулан судалсан улсуудад түгээмэл байна. Харин дотоод худалдааг гадаад худалдааны хууль шигээ нэгдмэл эрх зүйн актаар бус өөр өөр эрх зүйн актаар зохицуулж байна. Үндсэндээ зах зээлийн чиг баримжаатай улсуудад дотоод худалдааг *ерөнхийлөн нэг хуульд тусгах гэхээсээ* үндэсний эдийн засгийн онцлог, дотоодын үйлдвэрийн хөгжил, өрсөлдөх чадвар зэргийг харгалзан *аль салбарт шударга өрсөлдөөнийг дэмжиж нээлттэй бодлого баримтлах, аль салбарт дотоодын аж ахуй эрхлэгчдийг хамгаалах бодлого хэрэгжүүлэхээ салбар бүрт тусгайлан авч үзсэн шинжтэй байна.* Харин ОХУ-д дотоод худалдаандаа төрийн зохицуулалт нь нийтлэг байдлаар “... Оросын үйлдвэрлэгчдийг дэмжих”-д чиглэсэн байхаар хуульчилсан байна.

4. Монгол Улсын тухайд *дотоод, гадаад худалдааг хамтатгасан хууль эсхүл дотоод худалдааны нэгдсэн хуультай байхын алиныг нь ч шууд зөвлөхгүй.* Үүний оронд дээр онцолсончлон үндэсний эдийн засгийн онцлог, дотоодын үйлдвэрийн хөгжил, өрсөлдөх чадвар зэргийг харгалзан шударга өрсөлдөөнийг дэмжиж нээлттэй бодлого баримтлах эсхүл дотоодын аж ахуй эрхлэгчдийг хамгаалах бодлого хэрэгжүүлэхийн аль нэгийг зах зээлийн бодит судалгаанд үндэслэн салбар бүрээр тусгайлан тодорхойлох шаардлагатай байна. Дотоод худалдааны тухайд, жишээлбэл, жижиглэн худалдаа, түүний дотор сүүлийн жилүүдэд CU, GS25 зэрэг гадаадын ая тухтай дэлгүүр (convenience store) манай улсад олноор нээгдэн үйл ажиллагаа явуулж буй нь дотоодын жижиглэн худалдаа эрхлэгчид ямар нөлөө үзүүлж буй, энэ нь цаашид ямар төлөвтэй байгааг анхаарч төрөөс үр нөлөөтэйгөөр зохицуулах нь зүйтэй. Учир нь жижиглэн худалдаа эрхлэгчид нь салангид буюу нэгдсэн зохион байгуулалтад ороогүй, тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын нөхцөлд гадаадын сүлжээ дэлгүүрүүд нэгдмэл байдлаар/олноор орж ирэх нь алсдаа дотоодын жижиглэн худалдаачдыг зах зээлээс шахан гаргах, буцаж зах зээлд орж ирэхэд амаргүй байдалд хүргэх талтай.

[Ном зүй]

Г.Мөнхбаясгалан, Р.Шарбанди, Ж.Тунгалаг, *Глобал жижиглэн худалдааны орчин дахь Монгол Улс* (Journal of Business and Innovation (2023/№5(3), 154–167)

Ханнс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Арилжаа (худалдаа)-ны хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааны тайлан УБ.,2019

Г.Сэсээр, *Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал*, УБ., 2000

Э.Туулайхүү, *Экспортын хязгаарлалтад хамаарах ДХБ-ын эрх зүйн зохицуулалт ба Монгол Улсын нөхцөл байдал* (Эрх зүй сэтгүүл 2020/№1, 113-133)

М.Уянга, *Олон улсын худалдааны эрх зүй ба Дотоодын зах зээлийг хамгаалах арга хэмжээ* (УБ: Соёмбо принтинг, 2016)

МУГХЯ, *ДХБ дахь Монгол улс: Албан ёсны баримт бичгүүдийн эмхтгэл*, 2 дахь хэвлэл, УБ.,2003

Eun Sup Lee. “Regulation of International Trade in Korea under the WTO Mechanism”. Victoria University of Wellington Law Review 28 (3). Wellington, New Zealand: 513-26.

Mitsuo Matsushita, Thomas J. Schoenbaum, Petros C. Mavroidis, Michael Hahn. *The World Trade Organization: Law, Practice, and Policy* (Oxford: Oxford University Press, 2015),

Peter Van den Bossche and Werner Zdouc, *The Law and Policy of the World Trade Organization: Text, Cases and Materials* (Cambridge: Cambridge University Press, 2017)

Mongolia’s Trade Policy Review Report by the WTO Secretariat (12 December 2014)

Mongolia’s Goods Schedule (Schedule of Concessions and Commitments Annexed to the GATT 1994)

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр

Татаас ба саармагжуулах (хариу) арга хэмжээний хэлэлцээр

Хөдөө аж ахуйн хэлэлцээр

БНХАУ-ын Гадаад худалдааны хууль (Foreign Trade Law,1994)

ОХУ-ын Гадаад худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулахад баримтлах үндсэн зарчмуудын тухай Холбооны хууль (Федеральный закон «Об основах государственного регулирования внешнеторговой деятельности, 2003)

ОХУ-ын Худалдааны үйл ажиллагааг төрөөс зохицуулах үндсэн зарчмуудын тухай хууль (Об основах государственного регулирования торговой деятельности в Российской Федерации)

Япон улсын Гадаад гүйлгээ, гадаад худалдааны хууль (Foreign Exchange

and Foreign Trade Law, 1949)

БНСУ-ын Гадаад худалдааны хууль (Foreign Trade Act, 2016)

БНЭУ-ын Гадаад худалдааны хөгжил, зохицуулалтын тухай хууль (The Foreign Trade Development and Regulation Act, 1992)

Европын Холбооны зохицуулалт ((Council Regulation (EC) No 1061/2009 of 19 October 2009 establishing common rules for exports), (Regulation (EU) 2015/478 of the European Parliament and of the Council of 11 March 2015 on common rules for imports (codification))

<https://journal.num.edu.mn/BusinessAndInnovation/article/view/2374>

<https://ubn.mn/p/16588>

<https://www.unuudur.mn/a/259748>

https://www.wto.org/english/tratop_e/tpr_e/tp397_e.htm

https://www.wto.org/english/tratop_e/dda_e/status_e/sdt_e.htm

https://www.wto.org/english/tratop_e/scm_e/subs_e.htm

https://www.wto.org/english/docs_e/legal_e/24-scm.pdf

<https://docs.wto.org/dol2fe/Pages/SS/directdoc.aspx?filename=Q:/WT/ACC/MNG9A1-03.pdf&Open=True>

https://www.wto.org/english/tratop_e/tpr_e/s406_e.pdf

https://www.wto.org/english/thewto_e/glossary_e/de_minimis_e.htm

https://english.www.gov.cn/archive/laws_regulations/2014/08/23/content_281474982987386.htm

http://en.npc.gov.cn.cdurl.cn/2023-02/14/c_909612.htm

<http://kremlin.ru/acts/bank/20277>

<http://en.kremlin.ru/acts/news/73120>

<http://government.ru/docs/all/99391/>

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/21/en>

<https://oosga.com/briefings/jpn-trade-policies/>

https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=37529&lang=ENG

<https://www.wgtn.ac.nz/law/research/publications/about-nzacl/publications/nzacl-yearbooks/yearbook-3,-1997/Lee.pdf>

https://www.indiacode.nic.in/handle/123456789/1947?sam_handle=123456789/1362

<https://pib.gov.in/PressReleaseIframePage.aspx?PRID=1912572>

[Abstract]

Issues Regarding Legal Regulation of Trade in Mongolia

Enkhee Tuulaikhuu

Master of Laws (LL.M.)

*Lecturer at the Department of Public Law,
School of Law, National University of Mongolia*

Ulaanbaatar, Mongolia

Considering that the issue of how to regulate trade by law in Mongolia remains an ongoing research topic, this article aims to study the legal environment of trade in Mongolia, the legal regulations of the World Trade Organization (WTO), Mongolia's commitments, and the experiences of key trading partner countries. The goal is to determine the need for state regulation of trade, particularly through legislation, and to provide recommendations. The research findings indicate that Mongolia's main trading partners regulate foreign trade with separate laws, which could also be implemented in Mongolia. As a WTO member, it is crucial for Mongolia to develop and define its trade policies within the framework of WTO agreements to benefit from international trade rules, manage risks, and address legal issues. Trade laws typically define the basis of state policy for foreign trade separately, which is a common international practice. Following this, it is recommended to regulate foreign trade with a separate law while specifying regulations for domestic trade by sector. For example, in the retail sector, it is necessary to consider the impact of foreign chain stores and implement policies to protect domestic retailers.

[Keywords]

Trade, trade law, trade policy, foreign trade, domestic trade, and WTO agreements.